

## ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУДАЛГААНД ПРОЦЕССЫГ ХӨӨХ АРГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

*Н. Туяа\**

***Abstract:** This article introduces the concept of process tracing method in the social sciences. It does so by referencing the authors who have explained this method in a number of books and scholarly articles. The article states that the process tracing method seeks to answer the question “why did Y happen?” by identifying the many complex and interlocking causes, described as causal mechanisms, that lead to an outcome of interest. It explains that process tracing seeks to go beyond looking at correlations between variables and the “constant conjunction” between them as the source of causal inference and instead aims to “peer into the box of causality” to explain the dynamics that produce an outcome.*

***Key words:** Process tracing, causal mechanisms, deterministic ontology, mechanistic understanding of causality, causal inference, “diagnostic evidence,” within-the-case evidence, “interlocking parts,” invariant, eclectic theorization, pragmatism.*

\* \* \*

Сүүлийн жилүүдэд нийгмийн ухааны судалгаанд чанарын аргын нэгэн төрөл болох процессыг хөөх аргыг ихээхэн хэрэглэх болсон. Энэ өгүүлэлд тус аргын онцлох шинжүүдийг танилцуулахыг зорилоо. Товч хэлбэл, процессыг хөөх арга гэдэг нь нь тухайн судлагдаж байгаа нөхцөл байдал болон үзэгдлүүд тодорхой нэгэн үр дүнд (outcome) хүрсний шалтгаант хүчин зүйлүүд буюу шалтгаант механизмуудыг тогтоосноор үр дүнг тайлбарладаг. Улс төрийн ухааны эмпирик судалгаанд Х нь Y-д хүргэсэн шалтгаанжилт (causation) аль нэг тохиолдлыг ойлгоход төдийлөн хангалттай биш гэж үзэх үзлээс энэ арга үүдэлтэй. Y хэмээгдэх үр дүн *хэрхэн*, ямар механизмуудын үйлчлэлийн улмаас үүсэв гэдгийг тогтоох нь процессыг хөөх аргын зорилго байдаг. Энэ арга нь тодорхой нэгэн Х-ийн үр дагаврыг төдийлөн сонирхдоггүй, Y-д хүргэсэн олон янзын бөгөөд ээдрээтэй нөхцөл, төрх байдлуудыг онцгойлон сонирхдог учраас *хэрхэн*, *яаж* гэсэн асуултад хариулт эрэлхийлдэг. Өөрөөр хэлбэл, шалтгаант инференсыг (causal inference) хийхдээ хамаарагч, үл хамаарагч хувьсагчийн хоорондох шалтгаанжилтыг юм уу, завсрын хувьсагчийн нөлөөллийг сонирхохоос илүү үр дүнд хүргэсэн динамик шалтгаант процесс, шалтгаант механизмуудыг эрэлхийлдэг. Шалтгаант механизм гэдэг ойлголт нь тухайн тохиолдол дотор хэд хэдэн шалтгаант нөхцөлүүд тодорхой нэгэн дараалал, орчин нөхцөлд ажиллаж, өөр хоорондоо ажиллагаанд орж, нэгэн механизм болон бүрэлдэж, тэрхүү механизм нь тухайн үр дүнд хүргэнэ гэсэн санааг агуулдаг.

\* ГХЯ-ны Сайд асан, МУИС-ын ОУХНС-ийн докторант, судлаач

Энэ өгүүлэлд процессыг хөөх аргыг түүний тухай бичсэн судлаачдын ажлыг тоймлох байдлаар танилцуулна. Голчлон Andrew Bennett ба Jeffrey T. Checkel нарын *Process Tracing: From Metaphor to Analytic Tool* (2014), Derek Beach ба Rasmus Brun Pedersen нарын *Process-Tracing Methods: Foundations and Guidelines* (2013) бүтээлүүд дээр төвлөрөх авч ашигласан ном зүйд Alexander L. George ба Andrew Bennett нарын *Case Studies and Theory Development in the Social Sciences* (2005), Henry Brady ба David Collier нарын *Rethinking Social Inquiry: Diverse Tools, Shared Standards* (2010), James Mahoney-н “*After KKV: The New Methodology of Qualitative Research*” (2010) зэргийн бусад судалгаанууд мөн багтана.

Өгүүлэл гурван хэсгээс бүрдэнэ. Оршил хэсэгт процессыг хөөх аргын тодорхойлолтуудыг толилуулна. Дараа нь шалтгаант механизмуудын тухай илүү тодорхой өгүүлнэ. Эцэст нь тус аргыг хэрэглэх гурван аргачлалын тухай өгүүлнэ.

### ***Процессыг хөөх арга: тодорхойлолт буюу юуг хөөх вэ?***

‘Процессыг хөөх’ гэдэг хэллэгийг 1970-аад онд танин мэдэхүйн сэтгэл зүйд анх удаа хэрэглэсэн байдаг. 1979 онд Стэнфордын их сургуулийн Alexander L. George улс төрийн сэтгэл зүйн нэгэн судалгаандаа түүхчилсэн тайлбарын<sup>49</sup> тухай инференс хийхийн тулд тохиолдол доторх баримтыг (within-case evidence)<sup>50</sup> ашиглахыг процессыг хөөх арга гэж нэрлэснийг Bennett ба Checkel нар тэмдэглэжээ (2014:5). Аливаа тохиолдлыг тайлбарлах шалтгаануудын талаар инференс хийхийн тулд тус тохиолдол доторх баримтуудыг ашиглах аргыг буюу өнөөгийн хэллэгээр процессыг хөөх аргыг аль Фукудид-ын үеэс хэрэглэж ирсэн байдаг ба ерөөс хүмүүний дискурс, үйл ажиллагааг түүхчилсэн тайлбар, шалтгаант инференс хийхгүйгээр тайлбарлах боломжгүй байдгийг энэ хоёр судлаач тэмдэглэсэн байдаг.

Процессыг хөөх арга, түүний шинжүүдийг хэд хэдэн судлаач дэлгэрэнгүй дүрсэлж тодорхойлжээ. Van Evera (1997) түүнийг тодорхойлохдоо тухайн үзэгдэл, зан үйлийг хэд хэдэн хэсэг болгон авч үзэхийг чухалчилж, “үл хамаарагч хувьсагч ба үр дүнг/outcome холбох шалтгаан-үр дагаварын холбоосыг/link задалж, хэд хэдэн жижиг алхамд хувааж, дараа нь алхам бүрийн ажиглагдахуйц баримтыг эрэлхийлэх”-ийг процессыг хөөх аргыг хэрэглэсэн судалгаа хэмээн тодорхойлж байв (Van Evera 1997:64). Энэ аргыг жижиг n буюу цөөн тохиолдлуудыг, тухайлбал нижгээд гаж тохиолдлыг, судлахад дөхөмтэй гэж үздэг ба энэ арга нь шалтгаант механизмуудыг авч үзснээрээ аливаа нэгэн үр дүнг тайлбарлахад ганц хамаарагч хангалттай гэсэн үзлийг няцаадаг. Процессыг хөөх арга нь эмпирик, позитивист парадигмын хүрээнд багтдаг. (Дашрамд дурдахад, процессыг хөөх аргыг нийгмийн ухааны судалгаанд өргөнөөр хэрэглэх болсонд зарим судлаачид скептик байдлаар хандах нь бий. Тухайлбал, John Gerring (2009) шалтгаант механизм нь шалтгаанжилтын судалгааны нэгэн чухал боловч хоёрдогч элемент юм гэж үзээд түүнийг шалтгаанжилтыг тайлбарлах зайлшгүй нөхцөлд гэж үзэхийн эсрэг сэрэмжлүүлсэн байдаг.)

<sup>49</sup> *Түүхчилсэн тайлбар* нь үйл явдлын дарааллын деталчилсан тайлбарыг өгдөг ба тухайн үр дүнг шалтгаанжуулахад нөлөөлсөн чухал алхам бүрийг онол дээр суурилуулдаг (Bennett ба Checkel 2014; article 2012 – page 9).

<sup>50</sup> Bennett ба Checkel нарын томьёолсноор, *кэйс доторх баримт* гэдэг нь тодорхой цаг хугацаа, орон зай, сэдвээр нөхцөлдөх хүрээ хэмээн тодорхойлогдох кэйс-ийн дотор байрших баримтыг хэлнэ (хуудас 8 статья ном хуудас -?)

Процессыг хөөх арга нь “арга зүйг онтологитой ойртуулах” тухай Peter Hall-ын санааг илтгэсэн арга болохыг судлаачид мөн тэмдэглэдэг (Beach and Pedersen 2013). Beach ба Pedersen нар, “онтологи гэдэг нь нийгмийн ертөнцийн төрхийн талаарх, тухайлбал шалтгаанжилтын төрхийн талаарх, бидний ойлголт; эпистемологи гэдэг нь нийгмийн ертөнц дэх шалтгаант харилцаануудыг хэрхэн аль болох сайнаар судлах талаарх ойлголтууд” хэмээн тодорхойлоод (2013:5) Шотландын судлаач Давид Хьюмын шалтгаанжилтыг Х,У хоёрын хооронд тогтмол тохиолддог эмпирик холбоо (“constant conjunction”) байдлаар ойлгож, арга зүйд хэрэглэж ирсэн нь тухайн тохиолдол доторх шалтгаант процессыг илрүүлэхэд учир дутагдалтай хэмээн дүгнэсэн байдаг. Тухайлбал тэд, шалтгаанжилтыг тогтмол тохиолддог хэв жаяг байдлаар ойлгох нь “Х нь У-д хүргэж байгаа шалтгаант процессыг харанхуй үлдээдэг” хэмээжээ (2013:25). Тиймээс тэд, Рене Декартын механизмч (mechanismic) онтологийг үндэс болгож, тухайн тохиолдол дотор үйлчилж байгаа механик ажиллагаануудыг буюу хэсгүүдийг илрүүлэх аваас Х нь У-г үүсгэхэд нөлөөлсөн эсэхийг тогтоохоос илүү хэрхэн нөлөөлсөн, энэ хоёрын хооронд ямар шалтгаант процесс өрнөснийг олж тогтооход дөхөмтэйг тэмдэглэсэн байдаг (2013: 25). Шалтгаанжилтыг ийнхүү механизмч байдлаар төсөөлөх нь тогтмол тохиолдох холбоог агуулдаггүй учраас тохиолдлоос тохиолдолд учрах хэв жаягуудыг тогтоон судалдаг харьцуулсан судалгаанаас өөр юм.

George ба Bennett нар (2005) процессыг хөөх аргыг иж бүрнээр тайлбарласан нь дараа дараагийн судалгаанд чухал түлхэц болжээ. Тэд өөрсдийн анхны судалгаандаа процессыг хөөх аргад завсрын хувьсагчийн (intervening variable) үүргийг онцолж, “тохиолдол дахь завсрын хувьсагчдын дараалал ба ач холбогдлыг цэнэж хараад, [судалгаанд] хэрэглэж байгаа онолоор таамаглагдаж эсхүл ойлгогдож байгаа шалтгаант процесс тэнд үнэхээр оршиж буй эсэхийг тогтоохын тулд түүх, архивын баримтууд, ярилцлагын тэмдэглэл ба бусад эх үүсвэрийг ашиглахыг” процессыг хөөх арга гэж тодорхойлжээ (2005: 6). Процессыг хөөх арга нь тухайн процесс дотор өрнөсөн дундын (intermediate) алхмуудыг судалсны үндсэн дээр тус процесс хэрхэн өрнөсөн, үр дүнг хэрхэн үүсгэсэн, ерөөс үүсгэсэн эсэхийн тухайд дэвшүүлсэн таамаглалын талаар инференс хийдэг. Энэ арга, үл хамаарагч хувьсагч (эсхүл хувьсагчид) ба хамаарагч хувьсагчийн үр дүнгийн хоорондох завсрын шалтгаант процесс буюу шалтгаант хэлхээ ба шалтгаант механизмыг судлан тодруулахыг зорьдог гэдгийг George ба Bennett нар тэмдэглэж байв. Хожим Bennett, Checkel-тэй хамтран гаргасан номондоо (2014) завсрын хувьсагчид ач холбогдол өгсөн дээрх тодорхойлолтоос татгалзсан. Ингэснээ тайлбарлахдаа, нийгмийн ухаанд хувьсагч гэдэг ойлголтыг шалтгаан үүсгэгч (үл хамаарагч), шалтгаанжигч (хамаарагч) гэдгээр л ойлгож заншсан учраас процессыг хөөх аргад завсрын хувьсагч гэдэг ойлголтыг хэрэглэхэд будлиан үүсч болзошгүй гэжээ. Тэдний урьд өгсөн тодорхойлолтод завсрын хувьсагч нь үл хамаарагч хувьсагчаас бүрэн хэмжээнд шалтгаалж, түүний шалтгаан үүсгэх хүчийг ямарваа нэгэн нэмэлт, хасалт, өөрчлөлтгүйгээр дараа дараагийн завсрын хувьсагч(ид) руу - тэдгээрээр дамжуулан үр дагавар болох хамаарагч хувьсагч руу - шилжүүлж буй мэт байдал

үүсч байна. Гэтэл таамаглаж буй шалтгаан ба үр дагаварын хоорондох үйл явдлууд ийм шинжтэй байж болох ч эдгээр үйл явдлууд процесс дунд үл хамаарагч хувьсагчид нэмж нөлөөлсөн хүчин зүйлүүдээс шалтгаалсан байж бас болно; процесс дунд үүсэх хүчин зүйлүүд өөрийн гэсэн хүч нэмэх юм уу хүч сааруулах үйлчилгээ үзүүлсэн байж болохыг хоёр судлаач онцолжээ.

Тиймээс тэд завсрын хувьсагчийг тодорхойлолтоос хасаж, процессыг хөөх аргыг “тухайн тохиолдлыг шалтгаант утгаар тайлбарлахуйц шалтгаант механизмуудын талаар таамаглал боловсруулах эсхүл тестлэх зорилгоор түүн доторх процессууд, дарааллууд, үйл явдлын конъюктуруудыг илтгэх баримтыг шинжлэх явдал” хэмээн тодорхойлжээ (Bennett ба Checkel 2014: 7). Процессыг хөөх аргад онолыг тестлэх буюу дедуктив аргачлалыг хэрэглэхдээ байгаа онол дээр үндэслэн таамаглаж буй шалтгаант механизмууд тухайн тохиолдол дотор ямар нөлөөлөл үзүүлж буйг шинжин үзэж, тохиолдлыг тайлбарлаж чадаж байгаа эсэхийг тестэлдэг. Индуктив буюу онол боловсруулах аргачлал нь тохиолдол доторх нотолгоог хайн илрүүлсний үндсэн дээр тохиолдлыг тайлбарлах онолыг буюу механизмыг дэвшүүлдэг. Bennett ба Checkel нар процессыг хөөх аргыг индукц юм уу дедукцийг хэрэглэсэн нэгэн цул арга гэж үздэг.

Процессын хөөх арга нь парадигмын хувьд позитивист уламжлалд багтдаг. Судлаач баримт бичгүүд, дурсамж, контентын шинжилгээ, кэйс судалгаа, ярилцлага, хэвлэлийн мэдээ, түүхийн дурдатгал, ярилцлага, хүүрнэл зэргийн судалгаандаа ашигладаг. Хүүрнэлийг ашигласан тохиолдолд түүнийг түүхийн тайлбартай хутган ойлгох учиргүй юм. Bennett ба Checkel нар, микро-гүвшний түүхийн судалгаа процессыг хөөх аргатай ижилдүү харагдах боловч процессыг хөөх аргын онцлог нь бол онолоор тестэлж байгаа шалтгаант механизмуудын талаарх таамаглалыг битүү бус, ил гарган томъёолоход оршдог гэжээ (2014: 8-9). Энэ утгаараа, процессыг хөөх арга нь хүүрнэх хэлбэрийг ашигласан шинжлэх ухааны судалгааны арга зүй болдог (Ruback 2010: 480).

Beach ба Pedersen нар (2013) процессыг хөөх арга Y-ийн утгад X өөрчлөлт авчирсан эсэхийг биш, X нь шалтгаант механизм юм уу, механизмуудаар дамжуулан Y-г хэрхэн бий болгосныг нягтлахыг зорьдог гэдгийг цохжээ. Тэд процессыг хөөр аргыг “ганц тохиолдлын судалгаанд шалтгаант механизмуудыг судлах зэмсгүүд” гэж тодорхойлжээ (2013:2). Энэ арга нь үл хамаарагч, хамаарагч хувьсагчийн хоорондох корреляцийг илрүүлэхийг зорьдоггүй, кэйс дотор “ажиллаж” байгаа үйл явцууд буюу механизмууд үр дүнд хэрхэн нөлөөлснийг тогтоодог ба “аяж,” “хэрхэн” гэдэг асуултад хариулахыг зорьдог. Процессыг хөөх арга нь дедукц юм уу, индукцийг хэрэглэн шалтгаант механизмын ажиллагааны үр дүнд Y хэрхэн үүсэнийг судалдаг гэдэгтэй Beach ба Pedersen нар санал нийлдэг. Харин түүнийг нэгэн цул арга биш, дедукцийн хэрэглэдэг онолыг тестлэх аргачлал, индукцийг хэрэглэдэг онолыг боловсруулах аргачлал, судалгааны итератив стратегийг хэрэглэдэг үр дүнг минимум хангалттай байдлаар тайлбарлах аргачлал гэсэн гурван аргачлалыг багтаасан судалгааны арга хэмээн үздэг байна. Тэдний гурван аргачлалыг танилцуулахаас өмнө шалтгаант механизмуудын талаар илүү дэлгэрэнгүй өгүүлье.

### Шалтгаант механизмууд

Шалтгаант механизмыг тогтоох, илрүүлэх нь процессыг хөөх аргын зорилго байдаг. Судлаачид энэ механизмыг янз бүрээр тодорхойлсон байдаг. Ерөнхийлвөөс, аливаа нэгэн үзэгдэл, зан үйлийг процесс хэмээн үзэж, энэ процесс нэгэн үр дүнд хүрэхэд түүн доторх хүчин зүйлүүд өөр хоорондоо хэрхэн ажилласныг судлан тогтоохыг шалтгаант механизмыг тогтоох явдал гэж үздэг.

Дээр тэмдэглэсэнчлэн, Bennett ба Checkel нар процессыг хөөх аргыг авч үзэхдээ завсрын хувьсагч гэдэг ойлголтыг хэрэглэх нь тохиолдол доторх процессууд, дарааллууд, үйл явдлын конъюктуруудыг олж тогтоох явцаас анхаарлыг сарниулж, явцууруулж байна гэж үзээд түүнээс татгалзсан. Тэд ийнхүү татгалздаа, “оношлох нотолгоо” гэдэг ойлголтыг нэвтрүүлжээ. Таамаглаж байгаа шалтгаан, ажиглагдсан үр дүнгийн хооронд тухайн үр дүнд их, бага хэмжээгээр нөлөөлөн “ажиллаж” байгаа хүчин зүйлүүд үйлчилж байгаа бол тэдгээр нь “хувьсагч” биш “оношлох нотолгоо” (diagnostic evidence) болдог гэж тэд үзжээ. “Оношлох нотолгоо нь нэгэн төрлийн процесс явж байгааг илтгэнэ гэхээс биш хамаарагч хувьсагч руу бие даасан нөлөөлөл дамжуулдаггүй” гэж Bennett ба Checkel нар үзжээ (2014:7). Тэд, шалтгаант механизм байгаа эсэхийг оношлох нотолгоог тогтоохын тулд Stephen Van Evera-гийн (1997) боловсруулсан дөрвөн аргыг хэрэглэхийг санал болгосон байдаг.<sup>51</sup>

Процессыг хөөх аргад шалтгаант механизмууд үйлчилж байгааг харуулсан оношлох нотолгоонуудыг “шалтгаант процессын ажиглалт”-аар (causal process observation) илрүүлнэ гэсэн Brady ба Collier нарын (2010) санааг тэд дэмжсэн байдаг. “Шалтгаант процессын ажиглалт” нь тухайн өгөгдсөн тохиолдол дотор л болж байгаа орчин нөхцөл, процесс, механизмыг ажигладаг. Үүгээрээ энэ нь хэд хэдэн тохиолдолд хамруулан статистикийн шинжилгээ хийж болохуйц хувьсагчийн утгыг гаргадаг “өгөгдлийн багцын ажиглалтаас”(data-set observation) өөр юм (Brady ба Collier 2010: 12). King, Keohane, Verba (KKV) нарын (1994)<sup>52</sup> дэвшүүлсэн чанарын судалгааны арга зүйг регрессийн хэм хэмжээтэй уяж, статистикийн аргыг чухалчилдаг ажиглалтыг Collier, Brady, Seawright нар (2010) “өгөгдлийн багцын ажиглалт” (data set observation, DSO) гэж нэрлэжээ. Mahoney (2010) тэмдэглэхдээ, KKV нар процессыг хөөх аргыг шалтгаант инференсийг тодруулахдаа сул гэж үзэж, гагцхүү процессын дүрслэлийг гаргаж, шалтгаант шинжилгээ хийхэд үйлчилдэг эхний шат хэмээн үздэг байсныг заасан (Mahoney 2010: 123). Тэгвэл шалтгаант процессын ажиглалт нь процессыг хөөх явдлыг регрессийн хэм хэмжээнд уялдуулдаггүй, шалтгаант инференс хийхэд хувь нэмэр оруулахуйц мэдээлэл/өгөгдлийг тохиолдол дотроос эрэлхийлэхийг зорьдог байна.

<sup>51</sup> Эдгээрийг hoop tests, smoking gun tests, doubly decisive tests, straw-in-the-wind tests гэх ба энэ өгүүлэлд үүнийг тайлбарлахыг зорьсонгүй. Дэлгэрүүлэн эндээс үзнэ үү: Van Evera, Stephen. 1997. *Guide to Methods for Students of Political Science*.

<sup>52</sup> Gary King, Robert O. Keohane, Sidney Verba гурвын 1994 онд хэвлүүлсэн *Designing Social Inquiry: Scientific Inference in Qualitative Research* ном улс төрийн ухааны судалгааны арга зүйн сонгодог ном бөгөөд энэ талаарх концептуал мэдрэмжийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Нийгмийн ухааны чанарын судалгаанд тоон судалгааны аргууд, нэн ялангуяа регрессийн шинжилгээг, нэвтрүүлснээр судалгааны чанар сайжирна гэж үзэж байв.

Процессыг хөөх аргыг судлагчдын дунд шалтгаанжилтыг probabilistic буюу магадлалт шинжтэй гэж үзэх үү, эсвэл deterministic буюу учир зүйт шинжтэй гэж үзэх үү гэсэн маргаан бас байдаг. Bennett ба Checkel нар, “Бид магадлалт юм уу, учир зүйт ертөнцтэй учирч байна уу, эсвэл зарим үйл явц учир зүйт юм уу эсвэл учир зүйт шахуу байхад бусад үйл явц угаасаа стохастик байдаг уу гэдгийг 100 хувийн баталгаатай хэлж чадахгүй” гээд тайлбарлагдаагүй гаж заалт (error terms эсвэл random component) ба вариацийг тайлбарлахыг оролдохоо аль цэгт зогсоох вэ гэдгээ судлаачид өөрсдөө сонголт хийнэ гэжээ (2014:12). Тэд, үүн дээр үндэслээд “шалтгаант механизм гэдэг нь ертөнцөд байдаг онтологийн нэгж ба үйл явцууд юм, харин онол ба таамаглалууд бол бидний толгойд байдаг; бид механизмуудын талаар онолддог” хэмээн дүгнээд шалтгаант механизмыг дараах байдлаар тодорхойлсон байдаг: “зөвхөн тодорхой контекст ба нөхцөлд эрчим хүч, мэдээлэл, эдийг бусад нэгжид дамжуулж байдаг шалтгаан үүсгэх чадавхи бүхий агентуудаар нэвтэрдэг физик, нийгэм, сэтгэл зүйн үл ажиглагдах үйл явцууд” (2015:12). Beach ба Pedersen нар шалтгаант механизмуудыг үйлдэл дээр нь ажиглаж болох эсэх, эсхүл эдгээр механизмын бууж байгаа утгыг шууд бусаар ажиглахыг ажиглалт гэх эсэх дээр агностик байр суурь баримталж, үүн дээр ямар нэгэн байр суурь эзлэх логик шаардлага байхгүй гэж дүгнэсэн байдаг (2013: 32).


Цаашилбал, тэд шалтгаант механизмыг тогтоохыг хүсч байгаа бол шалтгаанжилтын детерминист онтологийг хэрэглэх ёстой гэж үзжээ (28). Учир нь гэвэл магадлалт шалтгаанжилт нь ертөнцөд санамсаргүй шинжүүд байдаг гэж үздэг учраас судлаач олонлог юм уу, түүвэр олонлогийг дамжсан шалтгаант үр дүнг судалж, тохиолдол хоорондын (cross case) судалгааны аргачлалыг хэрэглэдэг. Процессыг хөөх арга нь тохиолдол доторх процессыг судалдаг арга учраас судлаач “олонлоги доторх нэгэн X нь Y-тэй коварианцтай байгаа эсэхийг судалдаггүй, харин тухайн тохиолдол дотор X нь Y-н шаардлагатай эсхүл хангалттай шалтгаан болж чадаж байна уу” гэдгийг судалдаг (2013: 27). Beach Pedersen нар хувьсагч гэдэг ойлголтыг процессыг хөөх аргатай холбож хэрэглэхээс мөн л зайлсхийж, процесс дотор ажиллаж байгаа *нөхцөлүүд*, гарч байгаа *үр дүн*-гийн тухай ярьдаг.

Тэд, процессыг хөөх арга дахь шалтгаант механизмыг тухайн үр дүнг шалтгаанжуулсан завсрын хувьсагчдын эгнээ/цуваа мэтээр тодорхойлсныг бас учир дутагдалтай гэж үзжээ. Stuart S. Glennan-ы “*бүрэлдэхүүн хэсгүүд нь өөр хоорондоо ажиллагаанд орсон комплекс систем*” хэмээн шалтгаант механизмыг тодорхойлсныг иш үндэс болгож (2013:1) шалтгаанжилт завсрын хувьсагчаар бус, өөр хоорондоо холбогдсон “сэлбэг хэсгүүдээс” бүрдсэн механизмаар дамжин үр дүнг авчирдаг хэмээн тэмдэглэжээ. Эдгээр сэлбэг хэсгүүд завсрын хувьсагч бус, инвариант шинжтэй байх бөгөөд эдгээр хэсгүүд бүгд байсан нөхцөлд л механизм байж байна гэж үзнэ. Нэг ч болтугай “сэлбэг хэсэг” нь дутаж байвал механизм өөрөө байхгүй байна гэсэн үг (2013:38). Судлаач өөрийн онолдоо шалтгаант механизмыг ийнхүү машинтай ижилсүүлэн ойлгохдоо механизмын хэсэг болгоныг шүдтэй дугуй мэтээр төсөөлвөл зохилтой: шүдтэй нэг дугуй нь шалтгаант механизмын динамик шалтгаант энергийг нөгөө дугуй руугаа шилжүүлснээр эцэст нь Y үр

дүн үүснэ. Өөрөөр хэлбэл, нэг дугуйны шүд нөгөө дугуйныхаа шүдийг дэгээдэж аваад шүдтэй дугуйнууд өөр хоорондоо шалтгаант холбоосыг үүсгэнэ гэж Beach ба Pedersen нар үздэг.

Шалтгаант механизмыг завсрын хувьсагчийн эгнээ байдлаар үзсэний нэг жишээ болгож Rosato-гийн (2003) ардчилсан энх тайвны тухай судалгааг дараах зургаар харуулжээ:

Зураг 1.




Зураг 1-д шалтгаант механизмыг нэр үгээр (эргэх тооцоо, хүлээс) илэрхийлж, хувьсагч байдлаар харуулсан байна. Гэхдээ энд шалтгаант холбоосууд өөр хоорондоо хэрхэн ажиллаж байгаа нь харагдахгүй байгаа учраас шалтгаант механизм саарал хайрцганд орж байна. Түүнийг задлахын тулд Beach ба Pedersen нар “шалтгаант механизмын сэлбэг хэсэг болгоныг үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүдээс бүрдсэн” хэмээн концепцилж, эдгээр үйл ажиллагаанууд нь (механизмын сэлбэг хэсгүүд, өөрөөр хэлбэл шүдтэй дугуйнууд) шалтгаант хүчүүдийг механизмаар (дугуйны хөдөлгөөнөөр) дамжуулдаг гэжээ (2013:29). Энэ ойлголт дээр үндэслээд Beach ба Pedersen нар шалтгаант механизмыг дараах томъёоллоор дүрсэлжээ:

$$X \rightarrow [(n1 \rightarrow) \overset{*}{\rightarrow} (n2 \rightarrow)] Y$$

Энэ томъёололд механизмын хэсэг болгоныг  $(n1 \rightarrow)$  хэмээн дүрсэлсэн бөгөөд  $n$  гэдгээр үйл ажиллагаануудыг, сумаар үр дүнд хүргэж буй шалтгаант энергийг дамжуулагч үйл ажиллагааг, од тэмдгээр логик утга бүхий ба гэсэн санааг дүрсэлжээ. Шалтгаант механизмыг нэр үгээр илэрхийлэгдсэн завсрын хамрагчийн цуваа бус, үйл ажиллагаанд орсон нэгжүүдээр илэрхийлэгдсэн машины сэлбэг хэсгүүдтэй ижилсүүлэн ойлговол ардчилсан энх тайван дараах байдлаар үүсч байгаа юм:

Зураг 2.



Энэ томъёололд шалтгаант механизмын хүчин зүйлүүд хэрхэн өөр хоорондоо уялдаж, ямар үйл ажиллагаанд орж, улмаар хэрхэн тухайн үр дүнг авчирч байна гэдгийг харуулсан процессын динамик илэрхийллээ олсон байдаг. Тиймээс ч механизмыг нэр үг бус, *үйл үгээр* (гаргана, барина) илэрхийлсэн байдаг.

Дүгнэвээс, Bennett ба Checkel нар, Beach ба Pedersen нар аль аль нь процессыг хөөх аргын зорилго нь ямар шалтгаант механизмын улмаас тухайн тохиолдол тодорхой нэгэн үр дүнд хүрэх гэдгийг тогтооход оршино гэж үзэж байна. Мөн аль аль нь тус механизмыг тайлбарлахдаа завсрын хувьсагч гэдэг ойлголтоос зайлсхийх нь зүйтэй гэж үзэж байна. Харин эхний хоёр нь шалтгаант механизмыг илрүүлэхийн тулд түүнийг байна гэдгийг оношлох нотолгоог тестээр илрүүлэх учиртай гэж үзэж байгаа бол, удаах хоёр нь процесс доторх динамикийг үзүүлэхийн тулд механистик хандлагыг хэрэглэж, механизмыг нэг сэлбэг нь байхгүй л бол ажилладаггүй машинтай адилтган төсөөлөх нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн, Bennett ба Checkel нар процессыг хөөх аргыг индукц, дедукцийн аль алийг нь хэрэглэдэг нэгэн цул арга гэж үзэж байгаа бол Beach ба Pedersen нар энэ арга нь хэрэг дээрээ гурван аргачлалыг багтаадаг гэж үзэж байна.

### ***Процессыг хөөх аргын гурван аргачлал***


Beach ба Pedersen нар процессыг хөөх аргыг *онолыг тестлэх* аргачлал, *онолыг боловсруулах* аргачлал, *үр дүнг минимум хангалттай байдлаар тайлбарлах* гэсэн гурван аргачлалаар хэрэглэх бололцоотой гэж үзжээ. Эдгээрийн нийтлэг зүйл гэвэл аль аль нь шалтгаант механизмыг тогтоохыг зорьдог; детерминист онтологийг үндэс болгодог; нэг нэгийгээ “дэгээдсэн” хэсгүүдийн ажиллагааг агуулсан механизмын улмаас үр дүн үүсдэг гэж үзэх механистик ойлголтыг хэрэглэдэг; механизмыг инвариант шинжтэй буюу аль нэг хэсэг нь байхгүй бол механизм өөрөө байдаггүй гэж үздэг. Ялгаатай зүйл нь гэвэл, эдгээр нь эсхүл онол-төвтэй,



эсхүл тохиолдол төвтэй байдаг; онол-төвтэй бол шалтгаант механизмыг хэрэглэж буй онолынхоо дагуу эсхүл тестэлдэг, эсхүл шалтгаант механизм байгааг нотолсон онолоо боловсруулдаг; шалтгаант механизмыг ерөнхийлөх түвшин нь өөр байна (хэд хэдэн тохиолдол буюу олонлог дотор тохиолдох систематик механизм эсхүл тухайн тохиолдолд л хамрах механизм); онол-төвтэй аргачлалууд буюу онолыг тестлэх ба онолыг боловсруулах аргачлал нь механизм *байгаа/байхгүй* талаар инференс хийнэ, үр дүнг тайлбарлах аргачлал нь тайлбар *хангалттай* байгаа талаар инференс хийнэ (Beach ба Pedersen: 13).

Онолыг тестлэх аргачлал нь дедуктив арга бөгөөд таамагласан шалтгаант механизм тухайн тохиолдол дотор байгаа эсэхийг судлахад түүнийг хэрэглэдэг. Байгаа онолыг ашиглан механизмыг таамаглаж, улмаар эмпирик тест явуулж, нотолгоогоо гаргана. Ерөнхийдөө, онолыг тестлэхэд корреляц байга эсэхийг (X:Y), X ба Y-ийн хооронд завсрын хувьсагчаар дамжсан шалтгаант холбоо байгаа эсэхийг судалдаг. Процессыг хөөх аргын хувьд бол, онолыг тестлэхдээ процесс дотор өрнөж буй шалтгаант механизмыг таамаглаж, дээр танилцуулсан механизмик ойлголтыг хэрэглэж, *үйл ажиллагаа* явуулж байгаа *нэгжүүдээс* бүрдсэн *хэсгүүд* буюу сэлбэг хэсгүүдийг тогтоож, тэдгээр нь өөр хоорондоо хэрхэн ажиллаж, судлаачийн таамагласан механизм *хэрхэн* үр дүнд хүргэв гэдгийг тогтоодог. Судлаачийн зорилго нь хэрэглэж буй онол нь шалтгаант механизм байна гэдгийг харуулж байгааг нотлоход оршино. Нотолсон шалтгаант механизмыг зааглагдсан контекст дотор ерөнхийлж, өөр тохиолдлуудад хэрэглэж болно. Онолыг тестлэх аргачлалд концепцийн түвшинд дедуктив бодомж хэрэглэх авч эмпирик түвшинд нотолгоог эрэлхийлэхдээ индуктив бодомж хэрэглэх нь бас байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэ аргачлалыг холимог аргыг хэрэглэсэн судалгааны дизайнд хэрэглэж болно, гагцхүү хэрэглэж буй судалгааны онолыг детерминист онтологи дээр суурилуулсан байх, түүнчлэн инференс хийхдээ X-ийг X+механизм гэж авч үзэж композит хувьсагчаар төсөөлөх хэрэгтэй гэж судлаачид дүгнэсэн байдаг.


Зураг 3. Онолыг тестлэх аргачлал



Онолыг боловсруулах аргачлалд эмпирик материалыг цуглуулж судлан үзээд, тус материал дээр үндэслээд шалтгаант механизм байгаа эсэхийг хөөж, түүнийг нотолсон онолыг “босгодог.” Энэ нь индуктив арга бөгөөд түүнийг хоёр төрлийн судалгаанд хэрэглэдэг: нэгдүгээрт, Х ба Y-гийн хооронд корреляц байгааг мэдэж байгаа боловч судлаачид дагах онол байхгүй учраас энэ хоёрыг холбосон механизм нь тодорхойгүй байна (X-Y төвтэй онолын боловсруулалт); хоёрдугаарт, судлаач үр дүн болох Y-г мэдэж байгаа боловч түүнд хүргэсэн шалтгааныг мэдэхгүй байна. Сүүлчийн тохиолдолд судлаач Y-гээс арагш нь хөөж боломжит X-г эрэлхийлнэ, ингэснээр судалгаа мөн л X-Y төвтэй судалгаа болон хувирна (Beach ба Pedersen:16). Судлаачийн зорилго нь ажиглагдаж буй эмпирик нотолгоонууд шалтгаант механизм байгааг гэрчилж байна гэдгийг илрүүлэхэд оршино. Илрүүлсэн шалтгаант механизмыг зааглагдсан контекст дотор ерөнхийлж, өөр тохиолдлуудад хэрэглэж болно. Онолыг боловсруулах аргыг онолыг тестлэх аргын нэгэн адил дээр дурдсан хоёр нөхцөлийг хангасан тохиолдолд холимог аргыг хэрэглэсэн судалгааны дизайн хэрэглэж бас болдог байна.

Онолыг боловсруулах аргачлалыг процессыг хөөх аргад хэрхэн хэрэглэхийг дараах байдлаар харуулжээ:

Зураг 4. Онолыг боловсруулах аргачлал. (Хар зураас = шууд инференс; саарал зураас = шууд бус (хоёрдогч) инференс; саарал талбай = юуг хөөж буйг харуулна).



Онолыг боловсруулах аргачлалд үр дүнг тайлбарлах аргачлалтай нэгэн адил индуктив аргыг хэрэглэдэг. Гол ялгаа нь энэ аргачлал нь олж тогтоосон шалтгаант механизмыг судалгааны тухайн тохиолдлоосоо гадуур нэгэн заагтай контекстэд ерөнхийлөн хэрэглэж болохуйц дунд түвшний онол боловсруулахыг зорьдог.

Харин үр дүнг тайлбарлах аргачлал нь зөвхөн тухайн тохиолдлын үр дүнг минимум хангалттай байдлаар тайлбарлахыг зорьдог ба дээрх хоёр аргачлалаас ялгаатай нь онол-төвтэй бус, тохиолдол-төвтэй аргачлал юм. Дээрх хоёр аргачлалыг тухайн судалгаанаас гадуур өөр тохиолдлуудад хэрэглэх бололцоотой байдаг бол үр дүнг тайлбарлах судалгаа нь болоод өнгөрсөн нэг л үзэгдлийг хэд хэдэн механизмыг нийлүүлсэн эклектик хураавар (conglomerate) механизмаар тайлбарладаг. Судлаач, процессыг эклектик байдлаар хөөн судлахдаа хэрэгтэй мэдлэг бүрдүүлэх зорилгыг онолжилтынхоо түвшинд үндэс болгож, прагматик байдлаар судалгааны уламжлалуудыг нийлүүлэн хэрэглэдэг байна. Эклектизмын тухай энэхүү санааг Sil ба Katzenstein нар учирлан тайлбарласныг Beach ба Pedersen нар иш татсан байдаг (64).<sup>53</sup> Ерөөс, судлаачид ямарваа нэгэн өнгөрсөн үзэгдлийг тайлбарлахдаа онолыг тестлэх юм уу, боловсруулахыг төдийлөн зориод байдаггүй түүнийг тайлбарлахыг илүүтэйгээр оролддог учраас энэ аргачлалыг түлхүү хэрэглэдэг ба


<sup>53</sup> Прагматизмын тухай үзэлтэй эндээс танилцаж болно: Friedrichs, Jorg and Friedrich Kratochwil. 2009. "On Acting and Knowing: How Pragmatism Can Advance International Relations Research and Methodology." *International Organization* 63: 701-31.

үр дүнгээс цаг хугацааны хувьд арагш хөөж, тухайн тохиолдолд Ү ямар учраас бүрэлдэв гэдгийг хайдаг байна. Үр дүнг тайлбарлах судалгаанд Graham Allison-ы 1971 онд хэвлэгдсэн Кубын пуужингийн хямралын тухай сонгодог бүтээл, Frank Schimmelfennig-ийн Европын холбооны өргөжилтийн талаарх судалгааг дурддаг (63).

Үр дүнг тайлбарлах аргачлал нь судалгааны итератив стратегийг хэрэглэдэг ба систематик болон зөвхөн тухайн тохиолдолд хамаарахуйц (систематик бус) механизмуудаар үр дүнг тайлбарладаг (Beach ба Pedersen: 19). Ихэнх үр дүнг тайлбарлахад байгаа онолууд хангалттай тайлбар болж чаддаггүй учраас эклектик дедуктив онолчлоос гадна эмпирик нотолгоог индуктив аргаар хайж, тайлбараа оновтой болгох шаардлага гардаг. Судлаачийн хувьд гол асуулт нь энэ итерацийг хэзээ, аль цэгт зогсоох вэ гэдэг асуудал байдаг. Энд бүрэн хариулт байх боломжгүй бөгөөд тухайн үр дүнгийн ач холбогдолтой гэж үзэх бүх талуудыг нотолгоог ашиглан хангалттай тайлбарласан гэж үзсэн нөхцөлд зогсож болдог байна. Хоёр судлаач, юуг хангалттай тайлбар гэж үзэх вэ гэдэгт хариулахдаа, J.L. Mackie-г иш татжээ: “давхардсан зүйлгүйгээр үр дүнгийн бүх чухал аспектыг багтаасан тайлбар” (18).

Үр дүнг тайлбарлах аргачлалыг дараах байдлаар дүрсэлжээ.


Зураг 5. Үр дүнг тайлбарлах аргачлал



**Эмпирик, нижгээд тохиолдлын түвшин**

Дээрх гурван аргачлалын судалгааны зорилгыг Зураг 6-д дүрслэн харуулж байна. Судлаач, онолыг тестлэх аргачлалыг хэрэглэхдээ шалтгаант механизмыг онолчилж, тэр нь тухайн тохиолдол дотор байгаа эсэхийг тестэлнэ; онолыг боловсруулах аргачлалыг хэрэглэхдээ эмпирик нотолгоог цуглуулан судалж, өөрийн гэсэн онолыг “босгож,” шалтгаант механизмыг тогтоон гаргана; үр дүнг минимум байдлаар тайлбарлах аргыг хэрэглэхдээ үр дүнд хүргэсэн тайлбарыг толилуулна.

Зураг 6. Процессыг хөөх аргыг хэрэглэх гурван өөр аргачлал



## ДУГНЭЛТ

Процессыг хөөх арга нь сүүлийн жилүүдэд нийгмийн ухааны судалгаанд өргөнөөр хэрэглэгдэх болсон арга юм. Энэ арга, судлагдаж байгаа нөхцөл байдал/үзэгдлүүд тодорхой нэгэн үр дүнд (outcome) хүрсний шалтгаант зүйлүүд буюу шалтгаант механизмуудыг тогтоосноор тус үр дүнг тайлбарлахыг зорьдог. Чингэхдээ шалтгаант инференсыг хийхдээ хамаарагч, үл хамаарагч хувьсагчийн хоорондох шалтгаанжилт, эсхүл завсрын хувьсагчийн нөлөөллийг сонирхохоос илүү үр дүнд хүргэсэн шалтгаант процесс, шалтгаант механизмуудыг процесс дотор эрэлхийлдэг. Аливаа үзэгдэл, зан үйлийг процесс хэмээн үзвээс шалтгаант механизм нь тус процесс дотор өөр хоорондоо ажиллагаанд орж, эцсийн үр дүнг авчирсан динамик хэсгүүд юм. Зарим судлаачид ийм механмизм байгааг “оношлох нотолгоогоор” илрүүлнэ гэж үздэг бол зарим нь гурван аргачлалыг хэрэглэж түүнийг илрүүлнэ гэж үздэг байна.

Энэ өгүүлэлд процессыг хөөр аргыг танилцуулахдаа Andrew Bennett ба Jeffrey T. Checkel нар (2014) болон Derek Beach ба Rasmus Brun Pedersen нарын (2013) сүүлийн үеийн бүтээлийг иш үндэс болгосон болно. Энэхүү өгүүлэл болон доор өгөгдсөн ном зүй процессыг хөөх аргыг судалгаанд хэрэглэх, түүнийг цаашид үргэлжлүүлэн судлахад дөхөмтэй байх юм.

### НОМ ЗҮЙ

1. Beach, Derek and Rasmus Brun Pedersen. 2012. "Case Selection Techniques in Process-Tracing and the Implications of Taking the Study of Causal Mechanisms Seriously". *APSA 2012 Annual Meeting Paper*. Available at SSRN: <http://ssrn.com/abstract=2108908>
2. *Process-Tracing Methods: Foundations and Guidelines*. University of Michigan Press.. 2013
3. Bennett, Andrew. 2008. "Process Tracing." In Audie Klotz and Deepa Prakash, eds. *Qualitative Methods in International Relations: A Pluralist Guide*. New York: Palgrave Macmillan: 114-127.
4. "Process Tracing and Causal Inference." In *Rethinking.*, 2010.
5. *Social Inquiry: Diverse Tools, Shared Standards*, 2nd ed., ed. Henry E. Brady and David Collier, 207–19. Lanham, MD: Rowman and Littlefield.
6. "Using Process Tracing to Improve Policy Making: The (Negative) Case of the 2003 Intervention in Iraq." *Security Studies* 24: 228-238. 2015.
7. Bennett, Andrew and Jeffrey T. Checkel, eds. 2014. *Process Tracing: From Metaphor to Analytic Tool*. Cambridge University Press.
8. Blatter, Joachim and Markus Haverland. 2014. "Case Studies and (Causal-) Process Tracing" in Engeli, Isabelle and Christine Rothmayr Allison (eds.) 2014. *Comparative Policy Studies: Conceptual and Methodological Challenges*. London: Palgrave Macmillan: 59-83.
9. Bunge, Mario. 1997. "Mechanism and Explanation." *Philosophy of the Social Sciences*. 27: 410-465.
10. Henry, Brady E. and David Collier, eds. 2010. *Rethinking Social Inquiry: Diverse Tools, Shared Standards*. Lanham, MD: Rowman and Littlefield.
11. Collier, David. 2011."Understanding Process Tracing." *Political Science and Politics* 44 (4): 823-30
12. Friedrichs, Jürg and Friedrich Kratochwill. 2009. "On Acting and Knowing: How Pragmatism Can Advance International Relations Research and Methodology." *International Organization* 63 (4): 701–31.
13. George, Alexander L. and Andrew Bennett. 2005. *Case Studies and Theory Development in the Social Sciences*. Cambridge, MA: MIT Press.
14. Gerring, John. 2007. "Single Outcome Studies." *International Sociology* 21 (5): 707-734.
15. *Case Study Research: Principles and Practices*. Cambridge: 2007, Cambridge University Press.
16. "Causal Mechanisms: Yes, But..." *Comparative Political Studies* 43 (11): 1499-1526., 2010.
17. Glennan, Stuart S. 1996. "Mechanisms and the Nature of Causation." *Erkenntnis* 44: 49-71.
18. "Rethinking Mechanistic Explanation." *Philosophy of Science* 69 (Suppl): 342-353. 2002.
19. Goertz, Gary. 2006. *Social Science Concepts: A User's Guide*. Princeton: Princeton University Press.
20. Hall, Peter A. (2003) 'Aligning Ontology and Methodology in Comparative Politics', in James Mahoney and Dietrich Rueschemeyer (eds) *Comparative Historical Analysis in the Social Sciences* (Cambridge University Press), 373–404.
21. Hamati-Ataya, Inanna. 2012. "Beyond (Post) Positivism: The Missed Promises of Systemic Pragmatism." *International Studies Quarterly* 56 (2): 291-305.
22. Henry E. Brady and David Collier, eds. 2004. *Rethinking Social Inquiry: Diverse Tools, Shared Standards*. Lanham: Rowman and Littlefield, 362
23. King, Gary, Robert Keohane and Sidney Verba. 1994. *Designing Social Inquiry: Scientific Inference in Qualitative Research*. Princeton, NJ: Princeton University Press.

24. Lieberson, Stanley. 1991. "Small N's and Big Conclusions: An Examination of the Reasoning in Comparative Studies Based on a Small Number of Cases." *Social Forces* 70 (2): 307-320.
25. Mackie, J.L. 1965. "Causes and Conditions." *American Philosophical Quarterly* 2(2): 245-264.
26. Machamer, Peter, Lindley Darden and Carl F. Craver (2000) 'Thinking about Mechanisms.' *Philosophy of Science* 67(1): 1-25.
27. Mahoney, James. 2010. "After KKV: The New Methodology of Qualitative Research." *World Politics* 62 (1): 120-47.
28. "Process Tracing and Historical Explanation." *Security Studies* 24: 200-218., 2015.
29. Mearsheimer John J. and Stephen Walt. 2013."Leaving Theory Behind: Why Simplistic Hypothesis Testing Is Bad for International Relations." *European Journal of International Relations* 19 (3): 427- 457.
30. Ragin, Charles. 2008. *Redesigning Social Inquiry: Fuzzy Sets and Beyond*. Chicago: University of Chicago Press.
31. Robato, Sebastian. 2003. "The Flawed Logic of Democratic Peace Theory." *The American Political Science Review* 97(4): 585-602.
32. Ruback, Timothy J. 2010. 'Let Me Tell the Story Straight On': *Middlemarch*, Process-Tracing Methods and the Politics of Narrative. *The British Journal of Politics & International Relations* 12 (4): 477- 497.
33. Tannenwald, Nina. 2015. "Process Tracing and Security Studies." *Security Studies* 24: 219-227.
34. Schimmelfennig, Frank. 2001. "The Community Trap: Liberal Norms, Rhetorical Action, and the Eastern Enlargement of the European Union." *International Organization* 55 (1):47-80.
35. Schmitt, Johannes and Derek Beach. 2015. "The contribution of process tracing to theory-based evaluations of complex aid instruments." *Evaluation* 21: 429-447. University of Aarhus, Denmark
36. Sil, Rudra and Peter J. Katzenstein. 2010. "Analytic Eclecticism in the Study of World Politics: Reconfiguring Problems and Mechanisms across Research Traditions." *Perspective on Politics* 8 (2): 411- 431.
37. *Beyond Paradigms: Analytic Eclecticism in the Study of World Politics*. Basingstoke: Palgrave Macmillan. 2010
38. Van Evera, Stephen. 1997. *Guide to Methods for Students of Political Science*. Ithaca, NY: Cornell University Press.
39. Waldner, David. 2015. "Process Tracing and Qualitative Causal Inference." *Security Studies* 24: 239-250

